



**"НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН  
АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ  
БУУРУУЛАХ НЭГДСЭН ТӨСӨЛ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ" УТҮГ**

Нийслэлийн Нутгийн захиргааны цогцолбор Б блок,  
Наадамчдын зам 1200, Арцатын ам,  
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар хот, 17100  
Утас: (976) 7000 1936, 7000 1937  
Цахим шуудан: project@ulaanbaatar.mn

2024.12.04 № 1/672  
танай 2024.12.02 -ны № 03/2217 -т

**Тодруулгын хариу хүргүүлэх тухай**

Танай газраас 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр 03/2217 албан бичгээр ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. “Замын хөдөлгөөний хөдөлгөөнт хяналтын систем” – тэй нийцэж ажиллах талаар ямар нэгэн байгууллагаас зөвшөөрөл авах шаардлагагүй бөгөөд оролцогч байгууллага нь өөрийн санал болгож байгаа системийг тус системтэй зохицон ажиллах боломжтой талаар тайлбар нотолгоог ирүүлнэ.

2. Үндсэн болон дагалдах системийн программ хангамжууд нь өөр төрлийн буюу гуравдагч этгээдийн программыг ашиглахгүйгээр нэг цогц, харилцан уялдаатай ажиллах шаардлагатай байгааг тодорхойлж өгсөн. Өөрөөр хэлбэл цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх боломжтой, Та бүхнээс нийлүүлэгдэх систем, программ хангамж нь цогц систем байдлаар ажиллаж, тендерийн баримт бичигт заагдсан үндсэн систем байрших “Тээврийн цагдаагийн алба”-ны үндсэн серверээс бусад төрлийн систем, мэдээлэл боловсруулах программууд ажиллахгүй гэж ойлгоно.

3. Нийлүүлэлтийн хуваарьт багтаан барааны нийлүүлэлт, угсралт суурилуулалтыг хийнэ.

4. Техникийн тодорхойлолтын 12.8.7 радио холбооны станцын TX: 136-174MHz, RX: 136-174MHz гэж заасан байгаа нь цагдаагийн байгууллагад Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооноос зөвшөөрөгдсөн хэт богино долгионы радио давтамжийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд тухайн давтамжийн зурвас дээр дурдсан зурвасын өргөнд хамаарагдаж байх тул тухайн техникийн үзүүлэлтэд нийцүүлнэ.